



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭЭДЭЭ

151 /151/

2021.10.07



Үйл явдал

Түүхэнд энэ өдөр

## ТУУЛАХ ЧАДВАР САЙТАЙ АВТОМАШИНЫГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян нар өчигдөр Булган аймгийн Онцгой байдлын газарт ажиллаж

туулах чадвар сайтай ЗИЛ-131 маркийн автомашиныг хүлээлгэн өгч гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, тэмцэх, хойшлуулшгүй сэргээн босгох цаашдын ажилд нь амжилт хүслээ.

1968 он:

БХЯ-ны сайдын 236 дугаар тушаалаар Ардын армийн 109 дүгээр анги ЗХУ-аас ирүүлсэн "0719" дугаартай нидэг тэргийг хүлээн авчээ.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 12	☁️ -1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 21

## ҮБХИС 100 НАС ХҮРЛЭЭ



"Үндэсний батлан хамгаалахын их сургууль 100 жил" эрдэм шинжилгээний бага хурал өнөөдөр ҮБХИС-ийн "Сүбээдэй" танхимд зохион байгуулагдаж байна. Хуралд ҮБХИС-ийн үеийн захирал, багш, эрдэмтэн судлаачид оролцож байгаа юм. Тус хурлыг ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан нээсний дараа, ЗХЖШ-ын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Д.Номт ЗХЖШ-ын даргын мэндчилгээг уншиж танилцууллаа. Үргэлжлүүлээд ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал, хурандаа Б.Өлзийхуяг "Үндэсний батлан хамгаалах их сургууль-нэгэн зуунд" үндсэн илтгэл, БХЯ-ны ШУТЗ-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, хурандаа Д.Содномцог, "ҮБХИС нь Батлан хамгаалахын шинжлэх ухаан технологийн түшиц төв болох нь", Сургалтын хэлтсийн дарга, хурандаа Г.Болор "ҮБХИС-ийн сургалтын тогтолцоо, сургалтын чанар, хөгжлийн чиг хандлага" зэрэг хавсралт илтгэлүүдийг тавих юм.

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,849.00	2,851.00
EUR 🇪🇺	3,320,0	3,330,0
CNY 🇨🇳	441,5	442,5
RUB 🇷🇺	38,80	40,00
JPY 🇯🇵	25,31	25,83
KRW 🇰🇷	2,35	2,44

### ЗУРХАЙ

2021.10.07 ПҮРЭ В ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 1/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:  
Нас ахар болно  
Наран ургах, шинжих:  
07.00-18.20  
Барилдлага:  
Хотол чуулган  
Шүтэн барилдлага:  
Сансар  
Суудал:  
Гал

Тухайн өдөр бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛЛАЖ БАЙНА

Батлан хамгаалахын сайдын баталсан 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн удирдамжийн дагуу Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг харьяа анги байгууллага, аж ахуйн нэгжүүдийн Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн үйл ажиллагаа, өвөл сургуулийн бэлтгэл ажил, Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/230 дугаарын хэрэгжилттэй танилцан үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор харьяа байгууллагуудад ажиллаж байна.

## "СОЁМБО-ФОТО" ТАНЫ ГАРТ



Батлан хамгаалах салбар болон Зэвсэгт хүчинд өрнөж буй олон үйл явдлыг энэ өдрөөс эхлэн фото хэлбэрээр хүлээн авах дахин нэг суваг нээгдэж байгааг дуулгахад таатай байна.

Тодруулбал, "Соёмбо" редакаас "Соёмбо-Фото" цахим сониныг эрхлэн гаргаж байгаа бөгөөд Та бүхэн БХЯ, ЗХЖШ-ын вэбсайт болон манай редакцын "Soyombo сонин" пэйж хуудсаар хүлээн авч үзэх боломжтой. Түүнчлэн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарууд болон гадаадад үүрэг гүйцэтгэж буй Цэргийн багууд ЗХЖШ-ын Мэдээллийн аюулгүй байдлын албаар дамжуулан албаны мэйл хаягаар тус тус хүргэгдэх юм.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 311.462 +2409	ЭДГЭРСЭН 363.168 +713	НАС БАРСАН 1373 +14
-----------------------------------	--------------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5418 +95	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 194	ЭДГЭРСЭН 5118
-----------------------------	----------------------------	------------------

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 237,048,218
Эдгэрсэн Нийт: 214,187,571
Нас барсан Нийт: 4,839,383

## ТЭРБУМ МОД ТАРИХ АЖИЛД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БИЕ БҮРЭЛДЭХҮҮН НЭГДСЭЭР



Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин манлайлан оролцож байна. Тухайлбал, Батлан хамгаалах яам, харьяа байгууллагын алба хаагчид болон Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн бие бүрэлдэхүүн

тэрбум мод тарихад хувь нэмрээ оруулж байна. Тэгвэл өчигдөр Зэвсэгт хүчний ТХЦК болон 345 бригад, 084, 150 дугаар ангиудын удирдлага, бие бүрэлдэхүүн Төв аймгийн Аргалант сумын нутагт засмал зам дагуу 2000 мод тарих ажлыг эхлүүлээ. Үйл ажиллагааг

нээж ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал “Мод тарина гэдэг хүн байгаль хоёрын хоорондын зохицолд тун эерэг нөлөөтэй ажил. Байгаль эхээс шимтэй бүхнийг авдаг шигээ буцаагаад өгдөг байх хэрэгтэй. Нэг тэрбум мод тарих ажилд идэвхийлэн

оролцох нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, та бидний үүрэг юм. Зүгээр л тариад орхих биш усалгаа, арчилгаанд анхаарах нь хамгийн чухал” гэдгийг онцлов.

Мод тарих ажилд Аргалант сумын Засаг даргын орлогч Б.Ганзориг алба хаагчдын хамтаар нэгдсэн юм. Тэрээр “Өнөөдөр эхлүүлсэн энэ ажил илүү өргөжих учиртай. Цаашид 12 км газарт мод тарихаар төлөвлөсөн байгаа. Засмал зам дагуу мод тарьж, орчны өнгө үзэмжийг сайжруулж байгаа нь манай сум орон нутагт хийж буй нэг төрлийн хөрөнгө оруулалт гэж ойлгож байна. Батлан хамгаалах салбарынхан манлайлан оролцож байгаа энэ ажилд бусад албан байгууллага, аж ахуй нэгжүүд идэвхтэй хамрагдаарай” гэж уриалав. Мөн тарьсан модоо арчилж, тордох, эзэнтэй болгох чиглэлд тус сумын ЗДТГ-аас анхаарч ажиллана гэлээ.

Ажилтан алба хаагчдын сэтгэгдлийг хуваалцахад Зэвсэгт хүчний 150 дугаар ахлах дэслэгч Э.Үүрийнцолмон мод



тарих хөдөлгөөнд нэгдэх нь цэвэр агаар, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалахад маш эерэг нөлөөтэй гэж хэлсэн. Дундговь аймгийн уугуул тэрээр ЕБС-д байхаасаа мод тарьдаг болсноор цөлжилтийн эсрэг тэмцэлд багахан ч гэсэн хувь нэмрээ оруулж эхэлжээ. Цаашид ч өөрийн амьдарч байгаа орчинд мод тарьж, байгальд ээлтэй ажил өрнүүлнэ гэсэн юм.

Ангиудын алба хаагчид тус тусын байрлалд мод тарьж, хашаажуулахаас гадна нийгмийн хариуцлагын

хүрээнд ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэлээ.

Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн штабын үйлчлэгч Б.Мөнхцэцэгийн хувьд Ерөнхийлөгчийн санаачилсан мод тарих ажлыг дэмжиж гэр бүлээрээ нэгдсэн гэдгээ илэрхийлж байв. Үхрийн нүд зэрэг жимс жимсгэнийн мод тарьж ургуулсан туршлага байгаа учраас хашаандаа навчит мод сүндэрлүүлэхээр зорьж байгаагаа танилцуулж, “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэхийг уриалав.

## ЦЭРГИЙН ГАРДАН ТУЛААНЫ ДАШТ-Д МОНГОЛЫН ЗУРГААН ТАМИРЧИН ӨРСӨЛДӨНӨ



ОХУ-ын нийслэл Москва хотод гардан тулааны спортын ДАШТ энэ сарын 22-24-нд болно. Тэмцээнд 17 орны баг тамирчид өрсөлдөхөө мэдүүлсэн бол манай улсаас цэргийн гардан тулааны “Десант бамбар” клубийн захирал Д.Ганбаатарын удирдлага дор зургаан тамирчин эх орноо төлөөлөн оролцох юм.

Тэмцээний насанд хүрэгчдийн эрэгтэйчүүдийн ангилалд цэргийн гардан тулааны гурван удаагийн аварга, Азийн цомын хошой аварга, бүх Оросын аварга шалгаруулах тэмцээний хүрэл медальт Б.Наадам, мутай, жиүжицү бөхийн улсын аварга Б.Гантогтох, жиү жиүцү бөхийн



Азийн аварга А.Гантүлхүүр, эмэгтэйчүүдийн ангилалд ушу, мутайн спортын улсын аварга Н.Мягмарсүрэн нар өрсөлдөнө.

Мөн өсвөр үеийн ангилалд С.Нямпилжээ, Б.Алтансүх нар оролцохоор бэлтгэл сургуулилтаа

хангаж байна. Монголын баг тамирчид тус тэмцээнд анх удаа оролцох гэж байгаа нь энэ юм. С.Нямпилжээ нь “Токио-2020” паралимпын наадмын алтан медальт, гавьяат тамирчин Э.Содномпилжээгийн хүү аж.

## ЯПОН УЛСЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР НИЙЛҮҮЛЭГДСЭН ТЕХНИКҮҮДИЙГ ХҮЛЭЭН АВЛАА



Монгол Улс, Япон Улсын батлан хамгаалах салбарын харилцаа хамтын ажиллагааны хүрээнд Япон Улсын “Гал түймэртэй тэмцэх холбоо”-ны буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн техникуудийг хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ өчигдөр

Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид боллоо. Тодруулбал, яаралтай тусламжийн хоёр нэгж автомашиныг Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид, гал унтраах зориулалтын бүрэн тоноглогдсон гурван нэгж автомашиныг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, 015, 311 дүгээр ангиудад

тус бүр хуваарилах юм байна. Эдгээр техникийг хүлээн авснаар цар тахлын үед иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад шаардлагатай гал түймэртэй тэмцэх техникийн нөхөн хангалтыг бүрдүүлэх юм.

